



# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021-2024

*Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа эрхэм зорилго, стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, газрын бүтэц зохион байгуулалт, хяналт шинжилгээ-үнэлгээ хийх аргачлалыг тусгав.*

**АГУУЛГА**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**

|     |                                                    |   |
|-----|----------------------------------------------------|---|
| 1.1 | Стратеги төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл | 3 |
| 1.2 | Стратеги төлөвлөгөөний ач холбогдол                | 4 |
| 1.3 | Үндсэн зарчим                                      | 4 |

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАЗРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

|      |                                                           |    |
|------|-----------------------------------------------------------|----|
| 2.1  | НӨҮГ-ын захиралтай контракт байгуулах                     | 5  |
| 2.2  | Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх      | 7  |
| 2.3  | Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх               | 7  |
| 2.4. | Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн | 8  |
| 2.5. | Нийслэлийн өмчийг хувьчлах                                | 10 |
| 2.6  | Нийслэлийн өмчөөс төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх  | 11 |
| 2.7  | НӨҮГ-ийн газрын эдийн засгийн зорилтыг батлах, дүгнэх     | 11 |
| 2.8  | Мэдээллийн сан бүрдүүлэх                                  | 12 |

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ**

|     |                                                            |    |
|-----|------------------------------------------------------------|----|
| 3.1 | Газрын хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, эрхэм зорилго | 13 |
| 3.2 | Бидний эрхэмлэх үнэт зүйлс                                 | 13 |
| 3.3 | Байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилтууд            | 14 |
| 3.4 | Стратеги зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө   | 16 |
| 3.5 | Байгууллагын удирдлага, бүтэц зохион байгуулалт            | 22 |
| 3.6 | Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц     | 28 |

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

|     |                                          |    |
|-----|------------------------------------------|----|
| 4.1 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим      | 28 |
| 4.2 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй    | 29 |
| 4.3 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүд | 29 |

## **ӨМНӨХ ҮГ**

Монгол Улсад өмчийн олон хэлбэр үүсэж бий болсон 1990-ээд оноос Өмчийн ашиглалт, удирдлагын салбарыг манлайлж, газар болон байгалийн дагалдах нөөцийн үнэлгээ тогтоох, өмч хөрөнгийг түрээслүүлэх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг ажлын байраар хангах, төрийн төлөөллийг төрийн өмчийг эзэмшигч байгууллагууд, төрийн өмчийн оролцоотой болон хамтарсан компаниудад хэрэгжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлж гүйцэтгүүлэх, төрийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийлгэх, өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулан, үр өгөөжийг нэмэгдүүлэх, улмаар газрын төл5бөр, түрээс, өмч хувьчлалын орлого, ногдол ашгийг төсвийн орлого бүрдүүлдэг үндсэн эх үүсвэр болгох зэрэг Өмчийн ашиглалт, удирдлагын хөгжлийн явц дахь олон өөрчлөлт, шинэчлэлтийн анхдагч болсон.

Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь концессын ажлыг хэрэгжүүлж эхэлснээр төсөвт тусгагдаагүй их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай зам талбай, барилга байгууламжуудыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хөрөнгөөр бариулах, менежментийн нь тодорхой нөхцөлийн дагуу боловсронгуй болгон ашиглуулах, эзэмшүүлэх замаар төрөөс нийслэлийн иргэдэд хүргэн дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн сайжруулахад чиглэгдсэн өмчийг хувьчлахгүйгээр нийслэлийн өмчид хувийн хөрөнгө оруулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, дэд бүтцийн салбарт төсвийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтыг багасган, нийслэлийн төсвийн ачааллыг бууруулах үндэс суурь тавигдсанаар түүхийн шинэ үеийг эхлүүлсэн.

Энэхүү амжилт бүтээл нь газрын үе үеийн удирдлага, ажилтан, ажиллагсад, нийслэлийн өмчийг эзэмшигч болон хамтран ажиллагсад байгууллагуудын идэвх чармайлт, бүтээлч хөдөлмөрийн үр дүн мөн. Өнгөрсөн хугацаанд манай хамт олон хийж бүтээснийхээ хирээр туршлага хуримтлуулж, Өмчийн ашиглалт, удирдлагын талаар зохих мэдлэг боловсролтой ажилтан, ажиллагсад бүхий мэргэшсэн баг ажиллаж байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан эрхэм зорилго, стратегийн болон үйл ажиллагааны зорилтууд Нийслэлийн Засаг даргын Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэн таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг хангах, бодлогын баримт бичгийн холбогдох зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн болно.

Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд 2021-2024 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөөд буй арга хэмжээгээ хэрэгжүүлэхдээ төр, иргэний ашиг сонирхлыг дээдлэн, тэдний оролцоог ханган ажиллаж гүйцэтгэлийн үр дүнгийн талаар жил бүр Нийслэлийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүрсэн түвшинг баталгаажуулах, тогтвортой ахиулах, сул тал, эрсдэлийг бууруулж, давуу тал, боломжийг ашиглан, Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг ханган биелүүлэх, Засаг даргаас шийдвэр гаргахад мэргэжлийн арга зүй, санал зөвлөмжөөр хангаж ажиллахаас гадна газрын үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар иргэдэд ил тод нээлттэй мэдээлэлж ажиллах байх болно.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**

**1.1 Стратеги төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл**

- Үндсэн хууль
- Иргэний хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль
- Бусад хууль тогтоомж

Газар нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны тогтоолоор баталсан доорх журмууд:

|                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|---------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <i>НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоол</i> | <i>Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам<br/>Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам<br/>Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам</i>                                                               |
| <i>НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоол</i> | <i>Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам<br/>Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үлгэрчилсэн загвар</i>                                                                                                                                                                       |
| <i>НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоол</i> | <i>Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам<br/>Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам<br/>Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ<br/>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ</i> |
| <i>НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоол</i> | <i>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам</i>                                                                                                                                                                                                     |
| <i>НИТХТ-ийн 2014 оны 67 дугаар тогтоол</i> | <i>Нийслэлийн өмчийг хувьчлах журам<br/>Нийслэлийн өмч хувьчлах комиссын ажиллах журам</i>                                                                                                                                                                                                                               |
| <i>НИТХТ-ийн 2014 оны 68 дугаар тогтоол</i> | <i>Нийслэлийн өмчид үнэ төлбөргүйгээр шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам</i>                                                                                                                                                                                                         |

Нийслэлийн Засаг даргын Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэн таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

## 1.2 Стратеги төлөвлөгөөний ач холбогдол

Стратеги төлөвлөгөө нь Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын чиг үүрэг, байгууллагын эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нөөц бололцоо, хүчин чармайлт, цаг хугацаагаа юунд төвлөрүүлэх вэ гэдгийг оновчтой зохион байгуулж, тодорхойлох бодлогын баримт бичиг юм.

Дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд байгууллагын өмнө тулгарч байгаа асуудлыг тодорхойлон, даван туулах аргачлал, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, үр дүнд хүрэх ач холбогдолтой юм. Стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр иргэн хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгож, Өмчийн ашиглалт, удирдлагын бодлогын уялдаа холбоо сайжирч, байгууллагын дотоод зохион байгуулалт боловсронгуй болно.

Аливаа байгууллагын хамт олны идэвх, санаачилга, бүтээлч байдал, чин эрмэлзлийг дэмжиж, хөгжлийн төлөөх тэдний оролцоог нэгтгэснээр хөгжлийн бодлого, төлөвлөгөө биеллээ олж байдаг. Хамт олны хөгжлийн төлөөх оролцооны нэг хэлбэр бол тэдний оролцоотойгоор байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх явдал мөн.

## 1.3 Үндсэн зарчим

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмуудыг баримталсан болно. Үүнд:

1. Нэгдмэл цогц, харилцан уялдаатай байх
2. Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх
3. Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх
4. Нөөц бололцоонд үндэслэсэн байх
5. Ил тод, нээлттэй байх
6. Олон нийтийн оролцоог хангасан байх



Байгууллагын хөгжлийн үзэл баримтлал, эрхэм зорилго, үйл ажиллагааны хэтийн төлөв хүрэх үр дүнгийн төсөөллийг стратеги төлөвлөгөөнд тусгасан бөгөөд газрын дүрэм, хэлтсүүдийн чиг үүрэг зэрэгтэй нягт уялдуулж боловсруулсан.

## Арга зүйн асуудлууд:

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг газрын даргын тушаалаар байгуулан стратеги төлөвлөгөөнд хэлтсүүдийн дарга, ахлах мэргэжилтнүүд, албан хаагчдыг оролцуулан санал авч тусгуулан **өнөөгийн байдал, үндэслэл – орчны шинжилгээ - алсын хараа - эрхэм зорилго – стратегийн зорилтууд – үйл ажиллагааны зорилтууд – хэрэгжүүлэх арга механизм – гарах үр дүн – хяналт үнэлгээ** гэсэн арга зүйн дарааллын дагуу гүйцэтгэлээ.

Байгууллагын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах, хэлтсүүдийн болон хэрэгжүүлэгч агентлагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй ил тод, шуурхай болгох бодит шаардлагыг стратеги төлөвлөгөө боловсруулах явцад харгалзан үзэж, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн манлайлагч хамт олныг бүрдүүлэхийг эрхэм зорилгоо болгов.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ.**

**ГАЗРЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Монгол Улсад анх удаа хотын эдэлбэр газар, барилга байгууламжийг үнэлэх, түрээсийн төлбөр тогтоох, хураах, дахин үнэлгээ хийх, түрээсээр ашиглуулах, албан ажлын байрны зохицуулалт хийх чиг үүрэгтэй Хотын өмчийн газар /Нийслэлийн Өмчийн харилцааны газар/-ыг Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны 1991 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 36 дугаар тогтоолоор байгуулсан түүхтэй бөгөөд өнгөрсөн хугацаанд нийслэлийн өмчийн харилцаатай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт нь шинэчлэгдэн өөрчлөгдөж ирсэн.

Монгол Улсын Их хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолоор 504 байгууллагын 120,6 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг төрийн өмчөөс нийслэлийн өмчид шилжүүлэн өгсөн бөгөөд нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээр нийслэлийн өмчийн байгууллагын 4.110,2 тэрбум төгрөг болсон байна.



Засгийн газрын 2016 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай” 08 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/626 дугаар захирамжаар Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хэрэгжүүлж байсан чиг үүргээс газрын харилцаатай холбогдох чиг үүргийг Нийслэлийн Газрын албанд шилжүүлснээр Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь өмчийн харилцаатай холбоотой чиг үүргээ дангаараа хэрэгжүүлэх болж, 4 хэлтэс, 65 албан хаагчийн бүтэц, бүрэлдэхүүнтэй ажиллаж ирсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтэц, тэдгээрийн орон тооны хязгаарыг батлах тухай” 100 дугаар тогтоолоор тус газрын нийслэлийн Өмчийн харилцааны газрын нэр Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар болон өөрчлөгдсөн тул Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/241 дүгээр захирамжаар тус газар нь Захиргаа санхүүгийн хэлтэс, Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс, Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс, Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс гэсэн 4 хэлтэс, ашиглалтын захиргаа, нийт 65 /Төрийн захиргааны 38, төрийн үйлчилгээний 27/ албан хаагчтай ажиллаж байна.

***2.1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах***

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (дарга)-тай контракт байгуулан, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшингийн үндсэн үзүүлэлтийн биелэлтэд дүн шинжилгээ хийн, тухайн хуулийн этгээдийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны сүүлийн 2 жилийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй харьцуулан Контрактын биелэлтийг дүгнэх, дараа жилийн зорилтыг батлуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.


# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



## **2.2.Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх**


Нийслэлийн өмчит байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, өрхийн эрүүл мэндийн нэгдлийн удирдлагатай санхүүгийн тайлан тэнцэлд бүртгэлтэй өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг данс бүртгэлдээ тусгах, Өмч хамгаалах байнгын зөвлөлийг ажиллуулах, төсвийн хөрөнгийг зориулалтаар нь зарцуулах зорилгоор “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулан хэрэгжилтийг жил бүр дүгнэн ажиллаж байна.

Нийслэлийн болон дүүргийн төсөвт үйлдвэрийн газрын захиралтай 2019 оноос “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх” гэрээ байгуулж эхэлсэн, сургууль цэцэрлэг шинээр ашиглалтад орсноор 2019-2021 оны байгууллагын тоо үзүүлэлтүүд нэмэгдсэн байна.



## **2.3.Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх**

Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэх ажлын хүрээнд түрээсийн гэрээ байгуулж гэрээний биелэлтэд хяналт тавин жил бүрийн эцэст дүгнэн ажиллаж байна.



#### 2.4. Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн

НИТХТ-ын 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын дагуу нийслэлийн өмчит төсөвт байгууллага, үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөнд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг олж авах, бүртгэх, акталж данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх, худалдах (хөрөнгийн хөдөлгөөн) асуудлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна.

##### Нийслэлийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө худалдан авах

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн дагуу харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 70 сая төгрөг хүртэлх хөрөнгийг НӨХГ-ын дэргэдэх “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын (ЭБХХХК) хурлаар оруулан шийдвэрлэж байна.

Байгууллагаас хүсэлтийн дагуу 2015-2021 онд нийт **13,508.7** сая төгрөгийн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг олгосон байна.



##### Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх

Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон барилга байгууламж, шугам сүлжээ, тээврийн хэрэгсэл, нийтийн эзэмшлийн нийт **783,244.5** сая төгрөгийн хөрөнгийг 2015-2021 онд бүртгэсэн байна. Үүнд:


## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сая.төг



Байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2015-2021 онд хандив, тусламжаар бий болсон нийт **109,289.9** сая төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг ЭБХХХК-ын хурлын шийдвэрийг үндэслэн НӨХГ-ын газрын даргын тушаалаар данс бүртгэлдээ тусгах зөвшөөрлийг олгосон байна.

Сая.төг



### Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах

Байгууллагын хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, эрх бүхий байгууллага, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн гаргасан хүсэлтийн дагуу үл хөдлөх хөрөнгийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тээврийн хэрэгсэл, машин механизмыг Нийслэлийн Засаг даргын захирамж, бусад эд хөрөнгийг ЭБХХХК-ын хурлын шийдвэрийг үндэслэн НӨХГ-ын даргын тушаалаар данс бүртгэлээс хасахаар шийдвэрлэж байна.

НИТХТ-ын тогтоол, нийслэлийн Засаг даргын захирамжаар 2015-2021 онд нийт 83,928.7 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг данснаас хасахаар шийдвэрлэсэн байна.

Сая.төг




## 2.5. Нийслэлийн өмчийг хувьчлах

Хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг жил бүр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж хөрөнгө худалдах доод үнийг эрх бүхий хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын хийсэн тайланг үндэслэн тогтоож байна.

Өмч хувьчлалаар 2015-2021 онд нийслэлийн төсөвт нийт 72,592.2 сая төгрөг төвлөрүүлсэн бөгөөд үүнд менежментийн гэрээний үр дүнгээр хувьчлагдсан 1, барилга байгууламж 37 байна.

Сая.төг



## 2.6. Нийслэлийн өмчөөс төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх


Нийслэлийн төсөвт 2015-2021 онд нийт 93,412.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс түрээсийн орлого 14,168.5 сая төгрөг /15.2%/, өмч хувьчлалын орлого 14,168.5 сая төгрөг /77.7%/, ногдол ашгийн орлого 5,506.0 сая төгрөг /5.9%/, актлагдсан хөрөнгө худалдан борлуулсан орлого 1.2 сая төгрөг /1.2%/, байна.



## 2.7. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын ногдол ашиг төвлөрүүлэх

Нийслэлийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн зорилтыг жил бүр батлуулж, үйлдвэрийн газрын цэвэр ашгаас нийслэлийн өмчид ногдуулан төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг НИТХТ-ын хуралд санал оруулж жил бүр батлуулан нийслэлийн төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.

Нийт 15 үйлдвэрийн газрын батлагдсан ногдол ашгийн хэмжээ  
(2015-2021)



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Мэдээллийн нэр                                                    | хэмжих нэгж | Суурь түвшин | Суурь     |           |           |           |           |           |
|-------------------------------------------------------------------|-------------|--------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
|                                                                   |             | 2015         | 2016      | 2017      | 2018      | 2019      | 2020      | 2021      |
| Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой компаниуд                | тоо         | 7.0          | 7.0       | 7.0       | 7.0       | 9.0       | 9.0       | 9.0       |
| Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрууд /ОНӨТҮГ/             | тоо         | 10.0         | 13.0      | 13.0      | 13.0      | 14.0      | 15.0      | 15.0      |
| Өмч хувьчлалын жагсаалтад орсон ОНӨААТҮГ                          | тоо         | -            | -         | -         | -         | -         | 2.0       | 2.0       |
| Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд /ОНӨААТҮГ/ | тоо         | 22.0         | 16.0      | 16.0      | 15.0      | 17.0      | 15.0      | 15.0      |
| ОНӨААТҮГ-ын орлого                                                | саятөг      | 225,468.9    | 189,611.8 | 223,917.7 | 241,612.0 | 268,815.5 | 294,576.7 | 266,093.8 |
| ОНӨААТҮГ-ын зардал                                                | саятөг      | 233,909.8    | 237,335.2 | 240,535.8 | 274,640.4 | 304,126.6 | 347,214.2 | 304,911.9 |
| Ашиг алдагдал                                                     | саятөг      | 8,440.9      | 47,723.5  | 16,618.2  | 33,028.4  | 35,311.1  | 52,637.5  | 38,818.1  |

### 2.8.Мэдээллийн сан бүрдүүлэх


Нийслэлийн өмчит байгууллага болон хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, өмч хөрөнгийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, Төрийн өмчийн бодлого төлөвлөлтийн газарт тайлан мэдээ хүргэн ажиллаж байна.

| №                                                                                            | Мэдээллийн нэр                        | хэмжих нэгж | Суурь түвшин | Суурь      |           |          |          |           | Нийт      |
|----------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|-------------|--------------|------------|-----------|----------|----------|-----------|-----------|
|                                                                                              |                                       |             | 2015         | Chart Area | 2017      | 2018     | 2019     | 2020      |           |
| 1.Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, хөрөнгийн хөдөлгөөний тоон мэдээлэл |                                       |             |              |            |           |          |          |           |           |
| 1                                                                                            | Үндсэн хөрөнгийн дүн                  | тэрбум төг  | 1,340.8      | 1,796.1    | 2,087.9   | 3,823.2  | 4,114.3  | 4,833.2   | 16,654.7  |
| 2                                                                                            | Үүнээс: Эргэлтийн                     | тэрбум төг  | 150.9        | 403.8      | 506.7     | 603.8    | 933.9    | 1,704.3   | 4,152.5   |
| 3                                                                                            | Эргэлтийн бус                         | тэрбум төг  | 1,189.9      | 1,392.3    | 1,581.2   | 3,219.4  | 3,180.4  | 3,128.9   | 12,502.2  |
| 4                                                                                            | Хувьчилсан аж ахуйн нэгж              | тоо         | -            | -          | -         | 1.0      | -        | -         | 1.0       |
| 5                                                                                            | Хувьчилсан барилга, байгууламж        | тоо         | 14.0         | 4.0        | 8.0       | 1.0      | 2.0      | 7.0       | 22.0      |
| 6                                                                                            | Бүртгэсэн эд хөрөнгийн тоо            | тоо         | 510.0        | 419.0      | 215.0     | 141.0    | 291.0    | 563.0     | 1,629.0   |
| 7                                                                                            | 1.Барилга байгууламж                  | сая төг     | 79,494.3     | 138,614.3  | 128,025.3 | 62,660.7 | 53,149.9 | 102,920.3 | 485,370.5 |
| 8                                                                                            | 2.Тээврийн хэрэгсэл                   | сая төг     | 32,731.4     | 5,323.0    | 5,346.7   | 1,995.0  | 10,451.4 | 16,877.1  | 39,993.2  |
| 9                                                                                            | 3.Шинээр бий болсон хөрөнгө           | сая төг     | 40,418.3     | 59,935.9   | 69,325.6  | 9,078.4  | 17,610.3 | 42,586.0  | 198,536.2 |
| 10                                                                                           | Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгө | сая төг     | 10,892.3     | 7,817.4    | 10,223.1  | 631.3    | 5,282.6  | 13,660.1  | 37,614.5  |
| 11                                                                                           | Акталж данснаас хассан хөрөнгө        | сая төг     | 1,175.3      | 1,992.0    | 4,933.3   | 15,167.7 | 12,417.0 | 3,036.1   | 37,546.1  |

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1 Газрын хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, эрхэм зорилго



3.2 Бидний эрхэмлэх үнэт зүйлс:

|                                    |                                                                                                                                                                                                                                                                 |
|------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <u>Мэдлэгийг эрхэмлэх:</u>         | ✓ Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай мэдлэгтэй байж, түүнийгээ цаг үеийн эрэлт шаардлагад нийцүүлэн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлнэ.                                                                                                                |
| <u>Чадварыг эрхэмлэх:</u>          | ✓ Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохистой арга барил, ур чадвар, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг эзэмшиж, түүнийгээ ажлаа чадамгай, үр бүтээлтэй гүйцэтгэхэд ашиглана.                                                                      |
| <u>Хууль ёсыг эрхэмлэх</u>         | ✓ Төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн сахина.                                                                                                                               |
| <u>Ёс зүйг эрхэмлэх:</u>           | ✓ Төрийн албаны ёс зүйн үнэт зүйлс, зарчим, хэм хэмжээг сахин ажиллана.                                                                                                                                                                                         |
| <u>Шударга ёсыг эрхэмлэх:</u>      | ✓ Байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ямарваа хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй, ашиг сонирхлын зөрчилд өртөхгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, чин шударгаар ажиллана. |
| <u>Соёлтой харилцааг эрхэмлэх:</u> | ✓ Иргэдэд байнга хүндэтгэлтэй хандаж, тэдний итгэлийг олох хэмжээнд харилцааны соёлыг эзэмшин, үйл ажиллагаа,                                                                                                                                                   |

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

|                                             |                                                                                                                                                                                                                                                          |
|---------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                             | үйлчилгээгээ эелдэг, ил тод байлгаж, олон нийтийн санаа бодлыг байнга авч, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлж ажиллана.                                                                                                                                    |
| <u>Үнэнч байдлыг эрхэмлэх:</u>              | ✓ Төрийн албандаа ямагт чин сэтгэлээс өөриймсөг хандаж, албан үүргээ үр бүтээлтэй, илүү чанартай гүйцэтгэх талаар санаачилга, идэвхи зүтгэл гарган, иргэдэд төрийн үйлчилгээг бүрэн дүүрэн үзүүлэх талаар боломжтой бүх нөөц бололцоог ашиглаж ажиллана. |
| <u>Шуурхай байдлыг эрхэмлэх:</u>            | ✓ Байгууллагын үйл ажиллагааг явуулахад бусдад элдэв чирэгдэл учруулахгүй байж, ялангуяа иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтэд анхааралтай хандаж, боломжтой хамгийн бага хугацаанд шийдвэрлэн хариу өгөх хэмжээнд ажлаа зохион байгуулна.                  |
| <u>Хариуцлага, ил тод байдлыг эрхэмлэх:</u> | ✓ Хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан, ажилдаа эзэн болж түүнийхээ гүйцэтгэлийн үр дүнг биечлэн хариуцна.                                                                                                       |
| <u>Бүтээлч байдлыг эрхэмлэх</u>             | ✓ Хариуцсан ажлынхаа чиглэлээр шинийг эрэлхийлэх, шинэ ололт амжилтыг ажилдаа нэвтрүүлнэ.                                                                                                                                                                |
| <u>Багийн ажиллагааг эрхэмлэх:</u>          | ✓ Бусдыг хүлээн зөвшөөрч цаг ямагт багийн ажиллагааг эрхэмлэн ажиллана.                                                                                                                                                                                  |

### 3.3 Байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилтууд

Газар нь өөрийн чиг үүрэг, эрхэм зорилгоо хангахын тулд стратегийн дараах зорилтыг дэвшүүлж байна.

#### Удирдлага зохион байгуулалтын хөгжлийн зорилтууд

Төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх

1. Чанарын нэгдсэн удирдлага (MNS ISO 9001:2015) –ыг нэвтрүүлэх /ISO нь Олон Улсын Стандартын Байгууллага гэсэн үгийн товчлол/ Байгууллага өөрийн бодлого зорилгодоо хүрэхэд шаардагдах бүх зорилтын гүйцэтгэлийг хангах үйл явц, үйл ажиллагааны тогтолцоо юм.
2. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний үр нөлөөг тасралтгүй дээшлүүлэх

#### Бодлогын зорилтууд

Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой гарсан хууль тогтоомж, бодлогын зорилт, тусгай захиалгат ажлын биелэлтийг тайлагнах

*Хүрэх үр дүн:*

- ✓ Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана.
- ✓ Өмчийн харилцаатай холбогдон гарсан УИХ, ЗГ, НИТХ-ын тогтоол, НЗД-ын захирамж, санамж бичиг болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийн тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хангана.
- ✓ Газрын үндсэн чиг үүргийн хүрээнд дээд газраас өгсөн цаг үеийн шинж чанартай ажлыг түргэн шуурхай гүйцэтгэнэ.

### **Үйл ажиллагааны хөгжлийн зорилтууд**

Нийслэлийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих

- Нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, өмчийн менежментийн бодлого, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, удирдамжаар хангах, нийслэлийн өмчийг хувьчлах бодлого чиглэл, хөтөлбөр боловсруулан гаргаж хэрэгжүүлэх
  - Нийслэлийн өмчийн болон хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх
  - Нийслэлийн өмчид тавих хяналтын механизмыг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох
  - Байгууллагын дотоод хяналтын ил тод байдлыг хангах, хяналт, шинжилгээ-үнэлгээг сайжруулах
- Хүрэх үр дүн:*

- ✓ Нийслэлийн өмчийн менежментийг сайжруулах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- ✓ Дүүрэг болон нийслэлийн өмчийн хуулийн этгээдийг өмчийн нэгдсэн удирдлагаар хангана.
- ✓ Нийслэлийн өмчийн оролцоотой компаниудад нийслэлийн өмчийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ.
- ✓ Нийслэлийн өмчийг хувьчлах бодлого чиглэл, хөтөлбөр боловсруулан гаргаж хэрэгжүүлнэ.
- ✓ Нийслэлийн өмчийг ил тод, нээлттэй, үр ашигтай хувьчлах, нийгмийн салбарын хувьчлалыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- ✓ Шинээр өмч бий болгох эдийн засгийн үндсийг нэмэгдүүлнэ.
- ✓ Нийслэлийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, өмчийн талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгнө.
- ✓ Нийслэлийн өмчийн эзэмшилт ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.

### **Санхүүгийн хөгжлийн зорилтууд**

Төсвийн тухай, Төсвийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг зохион байгуулж, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

*Хүрэх үр дүн*

- ✓ Санхүүгийн удирдлагыг сайжруулна.
- ✓ Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн бодлого, хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангана.
- ✓ Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, ил тод байдлыг хангана.
- ✓ Байгууллагын санхүүжилтийг нэмэгдүүлнэ.
- ✓ Нийслэлийн төсвийн орлогын тодорхой хэсгийг нэр төрлөөр нь ханган биелүүлнэ.

### **Мэдээллийн технологи, техник, тоног төхөөрөмжийн хөгжлийн зорилтууд**

- ✓ Орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр шинэчлэх
- ✓ Шинэ дэвшилтэт мэдээллийн технологид суурилсан өмчийн харилцааг нэвтрүүлэх

### **Хүний нөөцийн хөгжлийн зорилтууд**

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, ур чадвар, чадавхыг бэхжүүлэх зарчмыг баримтлан, байгууллагын өмнө тавигдсан зорилго зорилтуудыг хэрэгжүүлэх суралцагч, мэргэшсэн, чадварлаг хамт олныг бүрдүүлэх

#### **Хүрэх үр дүн**

- ✓ “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, хувь хүний хөгжлийг дэмжих, албан хаагчдын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туслах, хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна.
- ✓ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газар болон хамтран ажиллагч, харьяа байгууллагуудтай хамтран сургалт, семинар зохион байгуулна.

### **3.4.Стратеги зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө**

Стратеги төлөвлөгөөнд стратегийн 5 зорилт, үйл ажиллагааны 22 зорилтыг томъёлон хэлтсүүдийн 56 бүтээгдэхүүнийг хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойллоо.

| Үндсэн чиглэл                                                                                                            | Хийгдэх ажлууд                                                                                                                                                                                                                                                                                                                                             | Хэрэгжүүлэх хугацаа |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|
| <b>УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД</b>                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                     |
| Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх                                                                                | Чанарын нэгдсэн удирдлага (MNS ISO 9001:2015)-ыг хэрэгжүүлэх                                                                                                                                                                                                                                                                                               | 2021                |
| Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний үр нөлөөг тасралтгүй дээшлүүлэх | Байгууллагын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд байгууллагын хэмжээнд төрийн захиргааны манлайллын үйл ажиллагааг хэрэгжүүлж, газрын өдөр тутмын үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах, бүтцийн нэгжүүдийн ажлын уялдаа холбоог төрийн албаны шуурхай удирдлагаар хангах                                                                    | 2021-2024 он        |
|                                                                                                                          | Төрийн албаны тухай хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод нээлттэй, шударга байж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх эрхэм зорилгыг удирдлага болгон цаг баримтлах, харилцааны соёлыг дээшлүүлэх, үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарчмыг баримтлан ажиллах | 2021-2024 он        |
| Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах                                | Иргэд үйлчлүүлэгчдэд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг нээлттэй ил тод, түргэн шуурхай хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах                                                                                                                                                                                   | 2021-2024 он        |
|                                                                                                                          | Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын талаар үзүүлэх үйлчилгээний тухай олон нийтэд мэдээлэх, сурталчлах, тэдний санал хүсэлтийг хүлээж авах ажлыг зохион байгуулах                                                                                                                                                                                       | 2021-2024 он        |

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

| БОДЛОГЫН ЗОРИЛТУУД                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                 |              |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
| Бодлогын зорилтын биелэлтийг дүгнэх, үр дүнг тооцох, хэрэгжүүлэх                                                                                                                                                                                              | Бодлогын зорилтын биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагааны жил, улирлын төлөвлөгөө боловсруулж батлуулах                                                                                                                                                                                            | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                               | Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу үр дүнг тооцон, биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр гарган, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргэх | 2021-2024 он |
| "Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний загвар" төсөл хэрэгжүүлж, "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эрүүл, баталгаат хоол хүнс хэрэглэх нөхцөл бүрдүүлэх                                                                              | Налайх дүүргийн сургуулиудад "Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг "Хангамж үйлчилгээний төв" ОНӨТҮГ-ыг түшиглэн хийх                                                                                                                                                                                       | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                               | Нийслэлийн Боловсролын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нийтлэг шаардлага боловсруулж, үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах                                                              |              |
|                                                                                                                                                                                                                                                               | Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран "Үдийн хоол" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих                                                                                                                                                                                                                 |              |
| Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлэх, нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ.                                                                                                        | Газар эзэмших ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг зохион байгуулах                                                                                                                                    | 2021 он      |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                 |              |
| Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авалтын төлөвлөгөөг ил тод болгон худалдан авалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж /хяналтыг сайжруулан/ тэвчиж болох худалдан авалт, удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулан төсвийн зардлыг хэмнэх | Нийслэлийн Засаг даргын захирамжаар Эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төслийг бэлтгэх үүрэг бүхий "Ажлын хэсэг" байгуулан ОНӨТҮГ-ын эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтыг батлуулж, шилэн дансанд байршуулах ажлыг зохион байгуулах                                                                 | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                               | Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын Эдийн засгийн зорилтот түвшний биелэлтийг дүгнэх, контракт гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах                                                                                                                                                                         |              |
|                                                                                                                                                                                                                                                               | Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулах                                                                                                                                                                                                                        | 2021-2024 он |
| Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд болон оролцоотой компаниудад компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх                                                                                                                                                 | Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудын ТУЗ, нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын УЗ-д төлөөлөл хэрэгжүүлэх, гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах санал боловсруулан шийдвэрлүүлэх                                                                                                             | 2021-2024 он |

# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

|                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |              |
|-----------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
|                                                                                                           | Компанийн засаглалын Үндэсний зөвлөлтэй "Хамтран ажиллах гэрээ" байгуулан "Сайн засаглал" сэтгүүл, МҮОНРТ-тэй хамтран бэлтгэдэг "Сайн засаглал" телевиз, радиогийн нэвтрүүлгүүд болон <a href="http://www.governance.mn">www.governance.mn</a> сайтаар ОНӨҮГ-уудын үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд таниулах                                                        | 2021-2024 он |
| НИТХ-ын тогтоолоор батлагдсан өмч хувьчлалын жагсаалтад орсон объектуудыг хувьчлах ажлыг зохион байгуулах | НИТХ-ын тогтоолоор нийслэлийн өмчөөс хувьчлахаар шийдвэрлэсэн хуулийн этгээд, эд хөрөнгийг хувьчлах бэлтгэл ажлыг хангах                                                                                                                                                                                                                                                  | 2021-2024 он |
|                                                                                                           | Холбогдох журмын дагуу өмч хувьчлалтай холбоотой асуудлуудыг НӨХК-ын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэн хэрэгжилтийг хангах                                                                                                                                                                                                                                                | 2021-2024 он |
|                                                                                                           | "Нийслэл хотын хөгжлийг дэмжих, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн шинэ эх үүсвэрийг бий болгох зорилгоор нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлийн бодит үнэ цэнийг тогтоох ажлыг зохион байгуулна." арга хэмжээний хүрээнд нийслэлийн өмчийн 18 барилга байгууламжийн зах зээлийн бодит үнэлгээг тодорхойлсон байна.                      | 2021-2024 он |
| Нийслэлийн өмчийн менежментийг сайжруулах                                                                 | "Нийслэлийн өмчийн менежментийг сайжруулах бодлогын баримт бичиг" боловсруулах, төслийг хэлэлцүүлэн, батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах                                                                                                                                                                                                                               | 2021-2024 он |
|                                                                                                           | Нийслэлийн өмчит байгууллагуудын дүрмийг холбогдох хууль журмын дагуу боловсруулан НИТХТ-ийн тогтоол, нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын бүтэц, орон тоог судлан боловсруулж, НЗД-ын захирамж гаргуулан, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах                                                                                                                                 | 2021-2024 он |
|                                                                                                           | "Сургалт эрдэм шинжилгээ, лавлагаа, тусламж үйлчилгээ үзүүлэх "Шүд, эрүү нүүрний төв"-ийн барилгыг худалдан авах асуудлыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх                                                                                                                                                                                        | 2021-2024 он |
|                                                                                                           | "Автобус-3" ОНӨААТҮГ-ыг өөрчлөн байгуулах асуудлыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх                                                                                                                                                                                                                                                                | 2021-2024 он |
|                                                                                                           | "Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компани төрийн өмчит компанийн тоог бууруулна." арга хэмжээний хүрээнд нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компанийн тоог 3-аар бууруулна. | 2021-2024 он |
| Нийслэлийн өмчийн төсөвт байгууллагуудын "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" дүгнэх                      | Нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудын "Нийслэлийн өмч эзэмшлийн гэрээ"-ний биелэлтийг дүгнэн, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах                                                                                                                                                                                                                         | 2021-2024 он |
| Улсын үзлэг тооллого хийх                                                                                 | Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавих                                                                                                                                                                                                                                                        | 2021-2022 он |

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

|                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |              |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
| Нийслэлийн өмчид шинээр бий болж байгаа хөрөнгийг бүртгэх                                                                                                                                                                                                                                 | Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын зээл, төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр шинээр бий болсон эд хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авах асуудлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангах                                                                                                                   | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                                                           | Нийтийн эзэмшлийн эд хөрөнгөө үнэ төлбөргүйгээр нийслэлд шилжүүлэн өгөх хүсэлт гаргасан иргэд, ААНБ-ын хүсэлтийг судалж шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх, холбогдох комиссын хурлаар хэлэлцүүлж, нийслэлийн өмчид бүртгэн авах асуудлыг шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангах                                                                                    | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                                                           | Нийслэлийн өмчид шинээр бүртгэгдсэн эд хөрөнгийн судалгааг хөрөнгийн нэр төрлөөр нь улирал тутам нэгтгэн гаргах                                                                                                                                                                                                                                                    | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                                                           | Тухайн жилд нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалтын судалгааг эх үүсвэр бүрээр гаргах                                                                                                                                                                                                                                                                                  | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                                                           | Өмнөх оны хөрөнгө оруулалтын судалгааг үндэслэн нийслэлийн өмчийн бүртгэлд тусгагдаагүй хөрөнгийг бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулах                                                                                                                                                                                                                        | 2021-2024 он |
| Нийслэлийн өмчит төсөвт байгууллага, үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөнд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг олж авах, бүртгэх, акталж данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх, худалдах асуудлыг шийдвэрлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнах, хариуцлага тооцох | Нийслэлийн өмчит байгууллагуудын хөрөнгө худалдан авах асуудлыг судлан, холбогдох газар, хэлтэст уламжлан, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах төсөл арга хэмжээнд <u>захиалагчийн хяналт</u> тавьж ажиллах                                                                                                              | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                                                           | НӨХГ-ын дэргэдэх Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцах комиссыг ажиллуулах                                                                                                                                                                                                                                                                                    | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                                                           | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны шууд худалдан авалт хийх босго үнээс дээш, харьцуулалтын аргаар худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаар хүртэлх үнийн дүн бүхий эд хөрөнгийн <u>худалдан авах</u> зөвшөөрлийг батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэрийг баримтлан олгох | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                                                           | Гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслээс бусад хөдлөх хөрөнгийг ЭБХХК-ын хурлаар оруулан <u>бүртгэх</u> асуудлыг шийдвэрлэх                                                                                                                                                                 | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                                                           | Илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг бусад байгууллагын <u>балансад</u> шилжүүлэн өгөх болон бусад байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгийг шилжүүлэн авах асуудлыг шийдвэрлэх                                                                                                                                                                               | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                                                           | Элэгдлийн хугацаа дуусч ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хугацаа нь дуусаагүй боловч цаашид ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэж ажиллах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, бусад хөдлөх <u>хөрөнгийг акталж, данснаас хасах</u> асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөл, НИТХТ-                | 2021-2024 он |

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

|                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                 |              |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
|                                                                                                                                                                                                                                                    | ийн хурал, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх, тайлант жилийн судалгааг гаргах                                                                                                                               |              |
| Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн системийг боловсронгуй болгох                                                                                                                                                                | Өмчийн мэдээллийн системийн баазыг шинэчлэх, холбогдох өөрчлөлтийг хийх, мэдээллийн системийн өгөгдлийг боловсруулж холбогдох байгууллагуудад мэдээ, мэдээллийг батлагдсан маягтын дагуу гарган хүргүүлэх                                                                                                       | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                    | "Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн санг бий болгох ажлыг эхлүүлнэ. " арга хэмжээний хүрээнд "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн программ хангамжийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнд ажиллан санал хүргэх | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                    | Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авах, тайлант хугацаанд хийгдсэн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг өмчийн мэдээллийн санд оруулсан эсэхийг байгууллага бүрээр шалгах                                                            | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                    | Нийслэлийн өмчийн 40-с дээш жил ашиглагдаж байгаа барилга байгууламжийн мэдээллийн санг бүрдүүлэх, үнэлгээ гаргуулах                                                                                                                                                                                            | 2021-2024 он |
| Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах                                                                                         | Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд шалгалт хийх, шийдвэр гаргуулах, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах                                                                     | 2021-2024 он |
| Нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр, талбайг түрээслүүлэх гэрээ байгуулах                                                                                                                                                                            | НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 65-р тогтоолын дагуу нийслэлийн өмчийг түрээслэгчийг сонгон шалгаруулах, нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр талбайг түрээсээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих                                                                                                     | 2021-2024 он |
| <b>САНХҮҮГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД</b>                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                 |              |
| "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Төсвийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, төсөв зохиож батлуулах, батлагдсан төсвийн дагуу хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, орлогын эх үүсвэрийг | Байгууллагын жилийн урсгал зардлын төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт тавих, орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэх, үргүй зардлыг багасгах, норм норматив тогтоох талаар арга хэмжээ авч ажиллах                                                                                                                 | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                                                                    | Санхүүгийн нэгдсэн бодлогын хүрээнд урсгал зардлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөнд зохицуулалт, өөрчлөлт оруулах санал өгөх, батлагдсан арга хэмжээг санхүүжүүлэх ажлыг хариуцан, зардлын гүйцэтгэлд хяналт тавих                                                                               | 2021-2024 он |

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

|                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                       |              |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
| нэмэгдүүлэх боломжийг судалж зохион байгуулах                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                       |              |
| Нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцсэн нэгдсэн программаар хөтлөх, Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт, санхүүгийн дотоод хяналт шалгалтыг сайжруулах | Байгууллагын хэмжээнд шилэн дансны тухай хуулийг мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллах                                                                                                                                                                                  | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                | Өр авлагын тооллого хийж, хэзээ хэрхэн үүссэн шалтгаан нөхцөлийг тогтоох, ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах, дүнг хагас бүтэн жилээр тайлагнах                                                                                            | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                | Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, тооллогыг хуулийн дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах                                                                                                   | 2021-2024 он |
| Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь ханган биелүүлэх                                                                                                              | Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр хуваарь гарган батлуулж, орлого төвлөрүүлэх                                                                                                                                           | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                | Нийслэлийн өмч хувьчлалын орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх                                                                                                                                                                                                       | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2017 оны жилийн эцсийн ашгаас нийслэлийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх                                                                                                                                                       | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                | Акталж данснаас хассан хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогыг төсөвт төвлөрүүлэх                                                                                                                                                                               | 2021-2024 он |
| Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд болон нийслэлийн өмчийн оролцоотой компаниудаас төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг төвлөрүүлэх                                                | Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд болон нийслэлийн өмчийн оролцоотой компаниудаас төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг тооцон, шийдвэрлүүлэх                                                                                                           | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                | Нийслэлийн Өмчит үйлдвэрийн газраас төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг нэмэгдүүлэх                                                                                                                                                                                      | 2021-2024 он |
| <b>ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД</b>                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                       |              |
| Төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын хариуцлагыг сайжруулах, хяналт тавих                                                                                                                       | Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2018 онд байгуулах үр дүнгийн гэрээний төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг улирал, жилээр гаргаж холбогдох газарт хүргүүлэх                                                                            | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                | Төрийн албаны стандартыг хангах чиглэлээр төрийн захиргааны албан хаагчидтай үр дүнгийн гэрээ, үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулах, ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлах          | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                                | “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд ажилтан, албан хаагчдыг сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг ажлуудыг үе шаттай зохион байгуулах | 2021-2024 он |

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

|                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                          |              |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
| Авлигын тухай хууль болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, албан хаагчдын сахилга дэг журам, ёс зүйн хэм хэмжээг сахиулах | Хуулийн үйлчлэлд хамаарах албан хаагчдын ХАСХОМ-ыг хүлээн авч нэгтгэх, мэдээ тайланг хугацаанд нь гаргуулж холбогдох газарт хүргүүлэх                                                                    | 2021-2024 он |
| Архивын хадгаламжийн нэгжийн эмх цэгц, үйл ажиллагааг сайжруулах                                                                                                               | Албан хэрэг хөтлөлт, хариутай бичгийн шийдвэрлэлтийг сайжруулах дээд газрын цохолттой албан бичиг, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж ажиллах                         | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                | Баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлыг зохион байгуулах, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байнга түр хадгалах баримтын данс бүртгэл батлуулах, баримт бичгийг журмын дагуу хүлээн авах, хяналт тавих | 2021-2024 он |
|                                                                                                                                                                                | Архивын тоон тайлан гаргах, Нийслэлийн Архивын газарт холбогдох журмын дагуу баримт, материалыг шилжүүлэх ажлыг зохион байгуулна.                                                                        | 2021-2024 он |

### 3.5. Байгууллагын удирдлага зохион байгуулалт

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар болон ажиллуулахаар шинэчлэн тогтоосон. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/214 дүгээр захирамжаар газрын бүтэц, орон тооны хязгаарыг баталж газрын дүрэм, гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах арга хэмжээ авахыг үүрэг болгосон.

Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоолын дагуу газрын даргын 2019 оны А/25 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан байгууллагын ажлын байрны шинжилгээ хийн, албан тушаалын тодорхойлолт боловсруулах мэдээлэл цуглуулах асуулга явуулан нэгдсэн мэдээ тайланг нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн ажилласан.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 111 дугаар тогтоолоор 37 /*газрын даргаас бусад*/, төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг баталсан. Тус тогтоолын дагуу газрын даргын 2020 оны А/204 дүгээр тушаалаар нийт 37 төрийн захиргааны албан хаагчдын А/230 дугаар тушаалаар нийт 27 төрийн үйлчилгээний ажилчдын албан тушаалыг тодорхойлолтыг баталсан.

Газрын бүтэц, чиг үүрэг

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241 дүгээр захирамжаар Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм болон 4 хэлтэс, орон тоог 65 хүртэл, үүнээс дарга, орлогч 2 байхаар баталсан байна.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/283 дугаар захирамжаар газрын дүрмийг шинэчлэн баталж дүрмийн 1.1-д **“Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны**

**хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх нийслэлийн өмчийн талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх, нийслэлийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцаж, холбогдох шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж ажиллах үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг”** гэж тодорхойлсон байна.



Газрын даргын 2019 оны А/204, А/230 дугаар тушаалаар Захиргаа санхүүгийн хэлтэс, Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс, Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс гэсэн 4 хэлтэс, ашиглалтын захиргаа /Урт цагаан үйлчилгээний төв, Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төв/, нийт 65 /ТЗ-38, ТҮ-27/ албан хаагчтай ажиллаж байна.


Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020.04.01-ний өдрийн 111 дүгээр тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын 24 ажлын байрны 37 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг зөвшөөрснөөр байгууллагын зорилго, чиг үүргийг биелүүлэхэд шаардагдах төрийн захиргааны албан хаагчдын мэргэшил, ур чадварыг тодорхойлсон байна.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241 дүгээр захирамжаар Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрыг 4 хэлтэс, орон тоог 65 хүртэл баталсныг үндэслэн Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны А/326 дугаар тушаалаар 4 хэлтэс, Урт цагаан үйлчилгээний төв, Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төв бүхий 65 орон тоог баталсан байна.


Тус 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 3 албан хаагчид хүүхэд асрах чөлөөтэй, 2 албан хаагчид түр томилогдон, нийт 61 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна.

# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ


## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ




## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



Байгууллагын нийт 37 төрийн захиргааны албан хаагчдыг хэлтэс бүрээр харьцуулалтыг харуулбал:



Нийт 4 хэлтсийн 37 захиргааны албан хаагчийн мэргэжлийг давхардсан тоогоор үзүүлбэл:



**Газрын үндсэн чиг үүрэг**

3.1 Нийслэлийг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл хөтөлбөр, тухайн санхүүгийн хугацааны төсвийн төслийг боловсруулахад оролцож, нийслэлийн удирдлагад дараах асуудлуудаар санал боловсруулж, шийдвэрийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1.1. нийслэлийн өмчөөс төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний төсөл;
- 3.1.2. нийслэлийн өмчөөс хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалт;
- 3.1.3. нийслэлийн өмчид шинээр олж авах эд хөрөнгийн жагсаалт, эх үүсвэрийн талаар;
- 3.1.4. нийслэлийн өмчид хийх техник технологийн шинэчлэл, их засварын төлөвлөгөөний төсөл;

3.2 Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар санал боловсруулж, шийдвэрийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.2.1. нийслэлийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах, бусдад шилжүүлэх асуудал;
- 3.2.2. нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалд хамрагдах боломжтой байгууллагуудын талаар;
- 3.2.3. нийслэлийн өмчид шинээр олж авах эд хөрөнгийн жагсаалт, эх үүсвэрийн талаар;
- 3.2.4. нийслэлийн төсөвт газрын удирдлагатай “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулах, гэрээг дүгнэх;
- 3.2.5. нийслэлийн өмчийн барилга байгууламжид өргөтгөл шинэчлэл, их засвар, техник, технологийн өөрчлөлттэй холбогдсон хөрөнгө оруулалт хийх;

3.3. Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй холбоотой дараах асуудлаар санал боловсруулж, шийдвэрийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.3.1. нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудал;
- 3.3.2. нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг оновчтой тогтоох;
- 3.3.3. орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;
- 3.3.4. хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх;
- 3.3.5. нийслэлийн өмчийн оролцоотой болон нийслэлийн өмчит хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл /Удирдах зөвлөл/-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар;
- 3.3.6. орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх;
- 3.3.7. нийслэлийн өмчит хуулийн этгээдэд олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг тогтоох;
- 3.3.8. нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай “Контракт” байгуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийг дүгнэх;

3.4. Орон нутгийн өмчийн бүртгэл, хяналт, ашиглалтын талаар санал боловсруулж, шийдвэрийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.4.1. нийслэлийн өмч /үл хөдлөх эд хөрөнгө бол сонгон шалгаруулалтын үндсэн дээр/-ийг иргэн, хуулийн этгээдэд түрээсийн гэрээгээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавих;
- 3.4.2. нийслэлийн өмчийн оролцоотой болсон нийслэлийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаа, санхүү, өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөрчил, дутагдлыг арилгахыг шаардах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- 3.4.3. нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьж, үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах;
- 3.4.4. нийслэлийн өмчид хийх хөрөнгө оруулалтын ажилд холбогдох шийдвэрийг үндэслэн захиалагчийн үүрэг гүйцэтгэх;

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

- 3.4.5. нийслэлийн өмчит байгууллагууд өөрийн эзэмшил эд хөрөнгө, газраа зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих;
- 3.4.6. нийслэлийн өмчит хуулийн этгээдэд олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг тогтоох;
- 3.4.7. өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;
- 3.4.8. нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөний талаар шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх асуудал;
- 3.4.9. Улсын Их Хурлын шийдвэрээр нийслэлийн өмчид шилжин ирж байгаа хөрөнгийг хүлээн авч бүртгэх, эзэмшигчид нь хүлээлгэн өгөх, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавих;
- 3.4.10. нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж бүртгэлжүүлэх;
- 3.4.11. нийслэлийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтыг хянах, баталгаажуулах ажлыг зохион байгуулах, хувийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийслэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгч байгаа нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авч, ашиглалт хариуцсан байгууллагад хүлээлгэн өгөх;
- 3.4.12. нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлснээс нийслэлийн өмчид хохирол учруулсан, үрэгдүүлсэн, шамшигдуулсан зэрэг өмч хөрөнгийн холбогдолтой маргаанд нэхэмжлэгчээр оролцох;
- 3.4.13. нийслэлийн өмчтэй холбогдон гарсан зөрчил, маргааныг зохицуулах, шийдвэрлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;


### 3.5. Дүүргийн өмчтэй холбогдох үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах

#### Хэлтсүүдийн эрхэм зорилго


|                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Захиргаа,<br>санхүүгийн хэлтэс                       | Төрийн албаны стандартын удирдлага, захиргааны болон хүний нөөцийн менежментийн үйлчилгээгээр хангах, байгууллагын дарга бусад албан тушаалтны хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд техник-зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх замаар байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, газрын үйл ажиллагаа, бодлого, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангах, хууль тогтоомжийн хэрэгжилт, холбогдох шалгуур үзүүлэлтийг хянаж санал, зөвлөмж гаргах, Төсвийн тухай, Төсвийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг зохион байгуулж, газрын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх |
| Өмчийн мэдээлэл,<br>хяналт,<br>ашиглалтын<br>хэлтэс: | Газрын үйл ажиллагаа, бодлого, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавих, дүн шинжилгээ хийн удирдлагыг мэдээллээр хангах, хууль тогтоомжийн хэрэгжилт, холбогдох шалгуур үзүүлэлтийг хянаж санал, зөвлөмж гаргах, нийслэлийн өмчийг түрээсийн гэрээгээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, хяналт шалгалт хийх, нийслэлийн өмчийн мэдээллийн сан бүрдүүлэх, нийслэлийн өмчит байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөний асуудалд хяналт тавих, нийслэлийн өмчтэй холбогдон гарсан зөрчил, маргааныг зохицуулах, нэхэмжлэгчээр оролцох, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах.                                                                                                                             |
| Өмчийн төлөөлөл,<br>менежментийн<br>хэлтэс:          | Нийслэлийн өмчийн бодлого боловсруулах, нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| Өмчийн бүртгэл,<br>хувьчлалын<br>хэлтэс:             | Төсвийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг бүртгэх, нийслэлийн өмчийг нэмэгдүүлэх, өмч хувьчлалаар төсвийн орлогыг бүрдүүлэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |

## 3.6. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам болон гэрээгээр хүлээсэн үүргийн шинжилгээ хийж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хэлтсүүдийн чиг үүргийг судалсны үндсэн 4-н хэлтсийн чиг үүргийн хуваарилалтын уялдааг хянан, давхардалгүй, ажлын ачааллыг жигд, хуваарилалтыг оновчтой болгон чиг үүрэгт өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна.



Төлөөлөл хэрэгжүүлдэг үндсэн 2 хэлтсийн хүрээнд:




## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

### Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх дотоод үйл ажиллагааны загвар



Байгууллагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэрийн хувьд газрын ажилчид болон байгууллагын зүгээс жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусгах замаар үндсэн бодлогын ажлуудыг хэрэгжүүлнэ. Мөн газрын дотоод үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нарийвчилсан төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

### Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх гадаад үйл ажиллагааны загвар



- Үндсэн чиг үүргийнхээ хүрээнд Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, шийдвэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын захирамж, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр гаргаж нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд санхүүгийн тайланг улирал тутам, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлнэ.

- Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын өмнөх оны эдийн засгийн зорилтот түвшний биелэлтийг дүгнэж, тухайн оны зорилтот түвшинг батлуулан, үйлдвэрийн газруудын захирлуудтай контракт гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.
- Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын зээл, төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр шинээр бий болсон эд хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авах асуудлыг хүсэлт ирүүлсэн байгууллагын бичиг баримт, холбогдох материалыг үндэслэн шийдвэрлэнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу Төрийн өмчийн бүртгэлийн шинэчилсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-д нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой төсөвт байгууллагуудын хөрөнгийн тайлан мэдээг хүлээн авч, ТӨ болон ТӨХ маягтын дагуу боловсруулж, ТӨБЗГ-аар дамжуулан Үндэсний Статистикийн газарт хүргүүлнэ.
- Дүүргийн үйлдвэрийн газрыг нэгдсэн удирдлагаар хангана.
- Нийслэлийн харьяа байгууллагуудыг эрхлэх асуудлын хүрээнд мэдээллээр ханган хамтран ажиллана.
- Газрын дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг нэг цэгээр дамжуулан хүргэнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

#### **4.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим:**

- 4.1.1. Газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хугацаанд үе шаттайгаар үнэлгээ өгөх ажлыг Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс хариуцна.
- 4.1.2. Газрын стратеги төлөвлөгөөг жил бүрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусгуулах, явцын хяналтыг тогтмол хийх үүргийг Захиргаа, санхүүгийн хэлтэс хариуцан ажиллана.
- 4.1.3. Газрын стратеги төлөвлөгөөнд явцын хяналт хийж, бүтэн жилээр биелэлтийг дүгнэх нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, удирдлагын үйл явцын үр нөлөөг үнэлж, сайжруулахад оршино.
- 4.1.4. Урьдчилсан болон нэгтгэн дүгнэх үнэлгээ нь хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүн, үр нөлөөг тогтооход чиглэнэ.
- 4.1.5. Стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох асуудлыг газрын даргын тушаалаар байгуулагдсан хяналт, шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

#### **4.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

- 4.2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно.
- 4.2.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг газрын дарга батална.
- 4.2.3 Тайланд хяналт-шинжилгээ хийхдээ хагас бүтэн жилээр гаргасан тайлан, мэдээтэй танилцаж баримт бичгийг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.
- 4.2.4 Бодлогын зорилтын хэрэгжилтийн түвшинг тодорхойлохдоо тавьсан зорилтын гүйцэтгэл тогтоох шалгуур үзүүлэлтийн үр дүнг (Гүйцэтгэл) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (Зорилт) харьцуулж хувиар илэрхийлнэ. ( $G/Z \times 100$ ).
- 4.2.5 Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 4.2.5.1 Тавьсан зорилтод бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол 100 хувь
- 4.2.5.2 Тавьсан зорилтод бүрэн хүрээгүй боловч санхүү, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь (80.0-100.0 хүртэл хувь)
- 4.2.5.3 Тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0-80.0 хүртэл хувь)
- 4.2.5.4 Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь (40.0-60.0 хүртэл хувь)

4.2.5.5 Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь (20.0-40.0 хүртэл хувь)

4.2.5.6 Тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0-20.0 хүртэл хувь)

4.2.5.7 Тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг “0” гэж үзнэ.

#### **4.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүд:**

4.3.1 Газрын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор улс, нийслэлийн төсвийг батлах, төсвийн тодотгол хийхээс өмнө үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай өртгийг нь тооцож, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

4.3.2 Бодлогын зорилтын суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн, үр нөлөөг тоон үзүүлэлтээр тогтооно. Тоон үзүүлэлт тогтоох боломжгүй бол чанарын шалгуур үзүүлэлтийг аль болох тодорхой тогтооно.

4.3.3 Тухайн үйл ажиллагаа болон бодлого хэрэгжиж эхлэх жилийн улсын статистик мэдээллээр гаргасан үзүүлэлт, төрийн байгууллагаас албан ёсоор гаргаж нийтэд мэдээлсэн тоон мэдээ зэргийг суурь үзүүлэлт болгон авна.

4.3.4 Шалгуур үзүүлэлт нь дараах шаардлагыг хангасан байна:

4.3.4.1 Хамааралтай буюу ач холбогдолтой байх

4.3.4.2 Урт хугацаанд хэрэглэгдэх, тогтмол байх

4.3.4.3 Хэрэглэхэд хялбар, боломжтой байх

4.3.4.4 Аль болох богино хугацаанд өөрчлөлтийг илэрхийлэхээр байх.

#### **4.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх**

4.4.1 Газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй холбогдуулан “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г баталж, дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.4.1.1 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах

4.4.1.2 Газрын стратеги зорилтоос хариуцсан чиглэлийн хүрээнд албан хаагчид өөрийн үр дүнгийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэх

4.4.1.3 Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн шаардлагатай тохиолдолд стратегийг хэрэгжүүлэх арга хэлбэр, зохион байгуулах үйл ажиллагааг өөрчлөх асуудлыг газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тодотгох.